



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/859

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар тогтоолоор “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр”-өөс Ховд аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж буй сэтгүүлчдийг чадавхжуулах, ажиллах нөхцлийг нь сайжруулах, сэтгүүлчдийг бие даан хөгжихөд дэмжлэг үзүүлэх зардалд 30 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан зарцуулагдах 30 000 000 төгрөг /гучин сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 тогтоолын 01 дүгээр хавсралт, Орон нутгийн хөгжлийн сангийн 4.1-д тусгагдсан “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих” хөтөлбөр”-өөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/859-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 24-ний өдрийн  
А/859 дүгээр захирамжийн хавсралт



### САНХҮҮЖИЛТИЙН ЗОРИУЛАЛТ, ДҮН

д/д	Зардлын нэр	Хийх ажил	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
<b>Зорилт 3,1 болон 3,5-ын хүрээнд</b>					
1	Хөтөлбөрийн дөрөвдүгээр зүйл, 4, 1,4 мөн 4.5.1-д тус тус заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зориулалтаар төсөвлөгдсөн зардал	Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн редакцын сургалт /цаг үеийн нөхцөл байдлаас үүдсэн зайны, онлайн сургалт, зайнаас дадлагажуулан сургах үйл ажиллагаа/-ны сургалтын төлбөр, мөн дадлагажигчдыг ажлын байран дээр дадлагажуулах, сургалтын материаллаг орчныг бүрдүүлэхэд зарцуулагдах зардал /2 удаагийн сургалтанд 9 байгууллага тус бүр 2-3 ажилтныг хамруулна/	444444,4		4000,000
		Хууль эрх зүй, иргэдийн оролцоо, боловсрол, соёл, эрүүл мэнд, нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн агуулга бүхий хэвлэл мэдээллийн шинэлэг бүтээгдэхүүнүүдийг бэлтгэх, түгээх бололцоог хангахад нь хэрэглэгдэх зардал <i>/Хөтөлбөрт хамрагдаж буй ХБМ-ууд сар тутам 3-аас доошгүй дээрх төрлийн контент бэлтгэн түгээх ба ажиллагсад нь энэ төрлөөр ажиллагсадаа дадлагжуулах/</i>	444444,4		4000,000
<b>Зорилт 3,2-ын хүрээнд</b>					
2	Хөтөлбөрийн 4,2,1-д заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зориулалтаар төсөвлөгдсөн зардал	Цар тахлын улбаагаар улс орон даяар үүссэн нөхцөл байдлаас болж, ХМБ-уудын орлого хумигдан, ажиллагсадаа цалинжуулж чадахгүйд хүрч буй тул, хөтөлбөрийн 4,2,1, мөн 4,3,1-д заасны дагуу зохих тооны ажлын байраа хадгалж үлдэхэд нь зориулсан санхүүгийн дэмжлэг олгох	1000,0	9	9,000, 000

**Зорилт 3,2 болон 3,3-ын хүрээнд**

3	Хөтөлбөрийн 4,2,3, мөн 4,3,1-д тус, тус заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зориулалтаар төсөвлөгдсөн зардал	<p>Үйл ажиллагаагаа амжилттай явуулахад шаардагдаж байгаа орчин үеийн технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, нэн шаардлагатай буй төхөөрөмж хэрэгсэл худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх.</p> <p>Ажиллагсдын хөдөлмөрийн харилцааг боловсронгуй болгож, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн хөдөлмөрийн эрх зүйн мэдээллийн сан бүрдүүлэх, хууль журам, гэрээний хэрэгжилтийг хангах ажлууд</p>	999, 9	9	8,000,000
	Хөтөлбөрийн 4,3,2, мөн 4,6,2-д тус, тус заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зориулалтаар төсөвлөгдсөн зардал	Бусад аймаг, хот, улсын ХМБ болон сэтгүүлчидтэй хамтран ажиллаж, харилцан суралцах, туршлага нэвтрүүлэх Салбарын хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн нэгдсэн үйл ажиллагаа Гүйцэтгэх багийн зардал	1250,0	4	5,000,000

-oOo-